

Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх



# Бурханы ХҮҮХДҮҮДДЭЭ ӨГӨХ ҮГС

**Б**урхан эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээснийхээ дараа хамгийн эхлээд тэдэнд хандан ярьсан гэдгийг бид судруудаас олж мэддэг.<sup>1</sup> Тэр чухал мэдээлэл, үнэт зааврыг тэдэнд өгөх хэрэгтэй байв. Тэр тэдний санааг зовоох эсвэл ачаалал өгөх биш харин аз жаргал, мөнхийн алдар суу руу удирдах зорилготой байжээ.

Энэ нь зөвхөн эхлэл байв. Тэр өдрөөс эхлэн өнөөг хүртэл, Бурхан Өөрийн хүүхдүүдтэй харилцаар ирсэн билээ. Үе үеийн шавь нар нь Түүний үгсийг бичин хадгалж, эрхэмлэн, тэдгээрээс суралцаар ирсэн юм. Бурханы хүслийг мэдэхээр эрэлхийлдэг хүмүүс эдгээр үгийг хүндэтгэн үздэг бөгөөд тэдгээр нь “Эзэн Бурхан зарц нар, эш үзүүлэгчиддээ Өөрийн нууцыг илчлэхээс нааш Тэр юуг ч хийхгүй”<sup>2</sup> хэмээх үнэнийг баталдаг.

Энэ хэв загвар нь эхлэлд ч ийм байсан бөгөөд одоо ч хэвээр үргэлжилсээр байна. Энэ нь зөвхөн Библийн сайхан түүх биш, харин Бурханы Өөрийнхөө хүүхдүүдэд чухал захиасуудыг өгдөг тогтсон арга зам юм. Тэр бидний дундаас хувь хүмүүсийг өсгөн, бошиглогчоор дуудаж, тэдэнд хэлэх үгсийг нь өгдөг бөгөөд бид тэдгээр үгийг “[Түүний] амнаас гарсан мэтээр”<sup>3</sup> хүлээн авах ёстой байдаг. Тэрээр “миний өөрийн дуу хоолой байна уу, эсвэл миний үйлчлэгчдийн дуу хоолой байна уу, энэ нь яг адил”<sup>4</sup> хэмээн тунхагласан юм.

Бурхан чимээгүй байдаггүй гэдэг нь Сэргээлтийн хамгийн агуу, урам өгөм, найдвар төрүүлэм захиасуудын

нэг юм. Тэр Өөрийн хүүхдүүдийг хайрладаг. Тэр биднийг харанхуйд төөрөхөөр орхиогүй билээ.

Жилд хоёр удаа буюу дөрөв, аравдугаар сард гайхалтай ерөнхий чуулганы үеэр Их Эзэний үгсийг үйлчлэгчдээр нь дамжуулан сонсох боломж бидэнд олддог.

Ерөнхий чуулганд үг хэлэх хүн нь үг хэлэхээр индэр рүү алхахаас ч илүү урт хугацааны өмнөөс эхлэн, үг хэлэх томилолтыг аваад их хичээл зүтгэл гаргаж, залбиран, суралцдаг гэдгийг би хувиасаа гэрчилж байна. Ерөнхий чуулганаар хэлдэг үгс бүрийн цаана маш олон цагийн бэлтгэл мөн Их Эзэн Өөрийн гэгээнтнүүдийг юуг сонсохыг хүсэж байгааг ойлгохыг хүссэн чин сэтгэлийн олон удаагийн залбирал байдаг.

Бид сонсогчдын хувьд үг хэлж байгаа хүмүүсийн адилаар бэлтгэвэл юу тохиолдож болох вэ? Хэрвээ бид ерөнхий чуулганыг Их Эзэнээс Өөрөөс нь захиасуудыг хүлээж авах боломж гэж үзэх юм бол ерөнхий чуулганд хэр өөрөөр хандах бол? Ерөнхий чуулганы үгс, дуу хөгжмөөр дамжуулан бид өөрсдөдөө тулгарсан ямар ч бэрхшээлдээ эсвэл асуултдаа хариултыг олж авч чадна.

Тэнгэрлэг Эцэг үнэхээр өөрт чинь хандан ярих болов уу гэж та нар бодож байсан бол, би та нарт Хүүхдийн хэсгийн “[Чи] Бурханы хүүхэд тул энэ эх дэлхийд [чамайг] . . . заяав” гэдэг дууны энгийн хэдий ч хүчирхэг үгсийг сануулмаар байна. “Нэгэн цагт Түүнтэй амьдрахын тулд” эргэн очиход тань туслах нь Түүний зорилго юм.

Та нар Тэнгэрлэг Эцэгт хүүхдийнх нь хувиар хандан, “Надад замаа олоход туслан, хөтлөн удирдаач . . . Юу хийх ёстойг заагаач” хэмээн чин сэтгэлээсээ Түүнээс гуйж болно. Тэр тангтай Өөрийн Ариун Сүнсээр дамжуулан ярих болно. Харин дараа нь “Түүний хүслийг дагах” эсэх нь танаас шалтгаална. Хэрвээ та дагах аваас “их адислал хүртэнэ”<sup>5</sup> гэдгийг би амлаж байна.

Дэлхийн түүхийн туршид байсны адил Их Эзэний удирдамж өнөөдөр ч бидэнд хэрэгтэй байгаа билээ. Бид Их Эзэний үгийг сонсохоор бэлтгэх явцдаа үнэний Сүнсийг хичээнгүйлэн хайх болтугай. Ингэж хайснаар Их Эзэн Өөрийн үйлчлэгчдээр дамжуулан ярих үед бид ойлгож, гэгээрэн мөн хамтдаа баясах болтугай.<sup>6</sup>

“Эдгээр зүйлүүдийг хийснээр тамын үүд [биднийг] дийлэх нь үгүй; тийм ээ, мөн Их Эзэн Бурхан харанхуйн хүчийг [бидний] өмнөөс сарниулж, мөн [бидний] сайн сайхан хийгээд түүний нэрийн алдар суугийн төлөө тэнгэрийг сэгсрэхэд хүргэх болно” хэмээн би гэрчилж байна.<sup>7</sup>

#### ЭШЛЭЛҮҮД

1. Эхлэл 1:28-ыг үзнэ үү.
2. Амос 3:7.
3. Сургаал ба Гэрээ 21:5.
4. Сургаал ба Гэрээ 1:38.
5. “Би Бурханы хүүхэд”, *Сүмийн дуулал болон хүүхдийн дуу* х. 58.
6. Сургаал ба Гэрээ 50:21–22-ыг үзнэ үү.
7. Сургаал ба Гэрээ 21:6.

## ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Ерөнхий чуулганы үеэр бид Бурханаас томилогдсон үйлчлэгчдийн үгсийг сонсохдоо өөрсдөдөө байгаа асуултуудад болон бэрхшээлүүдэд хариултуудыг хүлээн авч чадна. Заадаг хүмүүстэйгээ дараах асуултыг ярилцах тухай бодож үз. Ерөнхий чуулганы үеэр ийм хариултуудыг хүлээн авахад та хэрхэн бэлтгэж чадах вэ? Ерөнхийлөгч Угдорф биднийг “үнэний Сүнсийг хичээнгүйлэн хайхад” урамшуулсан. Энэ нь юу гэсэн үг гэж та бодож байна вэ? Мөн та үүнийг бэлтгэлдээ хэрхэн ашиглаж болох вэ? Сургаал ба Гэрээ 21:6-д дурдагдсан адислалуудаас гадна таныг Их Эзэний үйлчлэгчдээрээ дамжуулан хэлэх үгсийг сонсохоор бэлтгэх явцад ямар ямар адислал ирдэг вэ? Энэ ерөнхий чуулганаар Сүнсний тэдэнд заах зүйлсийг тэмдэглэлдээ бичиж авахыг та өөрийн заадаг хүмүүстээ урьж болно.

## ӨСВӨР ҮЕИЙНХЭН

### Бурханы үгсийг сонсохоор бэлтгэх нь

**Б**урхан эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээснийхээ дараа хамгийн эхлээд тэдэнтэй ярьж мөн тэдэнд эрхэм чухал мэдээлэл зааврыг өгсөн хэмээн ерөнхийлөгч Угдорф тайлбарласан. Бид дөрөв болон аравдугаар сард, ерөнхий чуулганы үеэр Сүмийн удирдагчид бидэнд хандан ярьж, Их Эзэний бидний сонсохыг хүссэн зөвлөгөөг өгөх үед мөн тэрхүү адислалыг хүлээж авдаг.

Танд ерөнхий чуулганы үеэр үйлчлэгчдээр нь дамжуулан Бурханы дуу хоолойг сонсож байсан үе байсан уу? Аль нэг тодорхой захиас таны эрж хайж байсан хариултыг өгсөн гэж танд санагдаж байсан уу? Та тэмдэглэлийн дэвтэртээ тухайн сэтгэгдлээ мөн энэ нь танд хэрхэн тусалсан талаар бичиж болно. Өөртөө байгаа асуултуудыг бичиж аван, судраас судлах үедээ тэдгээрийн талаар суралцсанаар болох гэж байгаа ерөнхий чуулганы үеэр Их Эзэний дуу хоолойг сонсоход бэлтгэ. Чуулганы үеэр хариултуудыг болон ойлголтуудыг авахыг гуйн Тэнгэрлэг Эцэгт хандан залбир. Их Эзэний үйлчлэгчдийг сонсохдоо зөвхөн танд зориулан өгөх сүнслэг өдөөлтүүд дээр анхаарлаа төвлөрүүл. Та юу сурсан бэ? Та юуг өөрчлөхөөр сүнслэгээр өдөөгдсөн бэ? Энэ нь Сүнс тангтай ярьж байгаа гэсэн үг учир эдгээр сүнслэг өдөөлтийг бичиж ав!

Тэнгэрлэг Эцэг танд хайртай бөгөөд таныг зөв замд удирдах болно гэдгийг үргэлжид санаж байгаарай. Та үйлчлэгчдээр нь дамжуулан Түүний дуу хоолойг сонсохоор чармайх үедээ адислагдан, гэгээрэх болно.

## ХҮҮХДҮҮД

### Чуулганд бэлтгэ!

**Э**дгээр сүнслэг өдөөлтийг цаасан дээр бич. Ерөнхий чуулганы үеэр тэр цаасаа харж бас сурсан зүйлээ бичиж ав.

Өөрт байгаа асуултуудаа бич. Би . . . талаар асуулттай байна.

Тэнгэрлэг Эцэгт хандан залбир. Надад . . . талаар сурахад тусламж хэрэгтэй байна.

Ерөнхий чуулганыг сонс. Би . . . тухай сурсан.



Итгэл, Гэр бүл, Халамж

# Эгч нарын төлөө тус бүрчлэн нэрээр нь залбир

*Бид айлчлан очдог эгч нарынхаа төлөө нэг бүрчлэн нэрээр нь даруухнаар залбирах үед бидний тэднийг хайрлах хайр, тэдний талаарх сүнслэг удирдамж нэмэгддэг.*

Сударуудад бусдын төлөө нэрийг нь дурдан залбирсан олон эрэгтэй эмэгтэй хүний жишээ байдаг. Эдгээрийн дундаас хамгийн мартагдашгүй жишээ нь залуу Алмагийн аавын залбирал юм. Тэнгэр элч залуу Алматай ярьж, эцэг нь “таны талаар их итгэлтэйгээр тэрээр залбирсан бөлгөө; тиймийн тул, энэ зорилгоор түүний үйлчлэгчдийн залбирлууд тэдний итгэлийнх нь дагуу хариулагдаж болохын тулд Бурханы хүч болон эрх мэдлийг танд итгүүлэхийн тулд ирлээ, би” (Мозая 27:14) хэмээн түүнд хэлдэг.

Нэг нэгнийхээ төлөө залбирах нь Их Эзэний бидэнд өгөхийг хүсэж байгаа адислалуудыг хүлээн авахад зүрх сэтгэлийг маань нээж өгдөг. “Залбирлын зорилго нь Бурханы тааллыг өөрчилдөггүй боловч биднийг аюулгүй байлгаж мөн бусдын төлөөх залбирлуудыг Бурхан соёрхоход бэлэн байдаг хэдий ч бид үүнийг олж авахын төлөө гүйн хүсэх ёстой.”<sup>1</sup>

Нэг эгч амьдралынх нь хэцүү бэрх цаг үед, “онцгой харанхуй өдрүүдэд” айлчлагч багш нараас нь олонтоо мессеж эсвэл утасны дуудлага ирдэг байсан тухай өгүүлжээ. Уг эгчид сэтгэлийн дэм хэзээ хэрэгтэй байгааг тэд мэддэг мэт байв. Айлчлагч багш нар нь айлчлах үедээ бас гэр гэртээ өөрийнх нь төлөө залбирдаг болохыг тэр эгч мэддэг байв.

Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгчөөр үйлчилж байсан Жюли Б.Бэк “Хэрэв эгч бүр өглөө, орой болгон чин сэтгэлээсээ эсвэл бүр Их Эзэний зарлигласан лугаа адил зогсолтгүйгээр залбирвал бидний нэгдмэл хүч чадал хэчнээн их байхыг бодоод үз дээ”<sup>2</sup> хэмээн хэлсэн. Айлчлан очдог тэднийхээ төлөө залбирах нь биднийг хувь хүний хувьд болон хожмын үеийн гэгээнтэн эмэгтэйн хувьд хүчирхэгжүүлдэг.

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, ерөнхийлөгч Хэнри Б.Айринг “. . . тэдний зүрх сэтгэлийн гүнд нэвтрэх арга замын

төлөө та нар залбирах болно. Та нар тэдэнд тусалж, тэднийг хайрлах Бурханы хайраар үүнийг бүх чадлаараа хийхийн тулд Бурхан та нараар юу хийлгэхийг хүсэж байгааг мэдэх ёстой”<sup>3</sup> хэмээн хэлсэн.

## ЭШЛЭЛҮҮД

1. Сударуудын удирдамж, “Залбирал.”
2. Жюли Б.Бэк, “What Latter-day Saint Women Do Best: Stand Strong and Immovable,” *Liahona*, 2007 оны 11-р сар, 110.
3. Хэнри Б.Айринг, “Санваар ба хувийн залбирал,” *2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 72.

## Үүнийг эргэцүүлэн бод

Өөрийн айлчлан очдог эгч нарын төлөө тус бүрчлэн залбирснаар танд ямар ямар сүнслэг өдөөлт болон санаа сүүлийн үед орж ирсэн бэ?

### Үйлчлэх нь

Бид эгч бүрийн төлөө нэг бүрчлэн залбирснаар тэдний хэрэгцээнд хэрхэн туслахаа мэдэх хувийн сүнслэг өдөөлтийг хүлээн авах болно.